



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/614

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын  
захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжид доор дурдсан өөрчлөлтийг оруулсугай.


1.1.Захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийслэлийн Төр захиргааны авто баазын зохин байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ын “Тээвэр зохицуулалтын хэлтэс-4.Диспетчер-механик “12” гэснийг “8” гэж”, 5.Үйлчилгээний жолооч “74” гэснийг “78” гэж өөрчлөх;

1.2.Захирамжийн 2 дугаар хавсралын “4.2.Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн болон Төрийн үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт, норм, нормативыг мөрдөх, соёлч боловсон, шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх” гэснийг “4.2.Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдөж, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх” гэж өөрчлөх.

2.Захирамжийн кодификаци хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газар (М.Үнэнбат)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725022959

